



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 6/16


Ховд

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.3.1, Захиргааны ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргаас албан ёсны чөлөө авахгүйгээр албан ажил тасалж, цалгардуулсан, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн тул Үенч сумын Засаг дарга Э.Уртнасанд сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлж, үүрэг хариуцлага, ажлын үр дүнгээ сайжруулан, холбогдох албан тушаалтнуудаа мэргэжил, арга зүйгээр хангаж, дахин зөрчил, дутагдал гаргахгүй ажиллахыг Үенч сумын Засаг дарга (Э.Уртнасан)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 1550